

## **2.1. Амарбаясгалант хийдийн төлөвлөлт, түүний архитектур**

### **Газрыг сонгох**

Хүрээ хийд байгуулах газрыг сонгохоос түүний төлөвлөлтийн асуудал эхэлдэг байна. Сүм хийдийн барилга барих газрыг сонгохдоо уул, ус нь тэгширсэн байгалийн үзэсгэлэнт газрыг чухалчлахаас гадна уг хийдийг барьж босгоход шаардагдах мод, чулуу, шавар, элс шороо зэрэг барилгын материалын олдоц, нөөц, баялгийг хүртэл судалдаг байжээ. Түүнчлэн байгалийн унаган төрхийг эвдэж өөрчлөхгүй, бэлчээрийг сүйтгэхгүй талаас нь анхаардаг байна. Амарбаясгалант хийдийг барих газрыг сонгохдоо хийдийн алсаас харагдах ерөнхий байдал, нарны тусгал, салхины чиглэл зэргийг тооцон орон зайн хамгийн зөв зохиомжийг олж барьсан байдаг.

Тухайн үед Амарбаясгалант хийдийг байгуулах газрыг сайтар шинжсэний дунд Түшээт хан аймгийн Ахай гүний хошууны нутаг байгалийн сайхан цогцлон бүрдсэн Бүрэн хан уулын өвөр, Ивэн голын хөвөөнд байгуулахаар товлон тогтжээ. “Товолсон газарт анх шинжээч нүхтэй зоос булж орхижээ. Жилийн дараа ирсэн өөр нэгэн шинжээчийн төлөгт бас тэр газар таарч алтан тэвнэ хатган үлдээжээ. Хийдийн шав тавих болж шинжээчдийн хийж орхисон тэмдгийг авч үзвэл анхны булсан зоосны нүхээр хожмын тэвнэ орсон байдаг” гэсэн домог яриа байдаг.

Түүнчлэн Оросын түвд-монголч эрдэмтэн Г.Ц.Цыбиков 1895 оны долдугаар сард Амарбаясгалант хийдэд очиж хоёр хоногдоо Амарбаясгалантыг үндэслэн байгуулсан тухай өөр нэг домог яриаг сонссоноо тэмдэглэж үлдээсэн байна. Тухайлбал, “Нэг удаа Манжийн хааны амбан Өндөр гэгээнийг манжийн эзэн хааны хаан ширээг булааж байна гэж зүүдэлснээ хаандаа айлтгахад, тэгвэл би Өндөр гэгээнийг яаж зогсоох вэ? хэмээн

асуухад амбан дахин зүүдлээд Өндөр гэгээнд зохимжтой газар ордон барьж өг гэж хэлжээ. Тэгээд хаан газар сонгуулахаар мэргэч төлөгч явуулжээ. Төлөгч Бүрэн хан нурууны өмнө талын тохиromжтой газрыг сонгоод тэнд очиход хоёр хүүхэд хонь хариулж байжээ. Төлөгч нэрийг асуухад нэг нь Амар, нөгөө нь Баясгалан гэжээ. Эрэгтэй хүүхдийг нь алаад байран дээр нь Цогчин дуганыг босгожээ” хэмээн тэмдэглэжээ [Цыбиков Г.Ц. 1991, с.102].

Өнөөдөр Амарбаясгалант хийд нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт, хойд өргөрөгийн  $49^{\circ}28'47.0''$ , зүүн уртрагийн  $105^{\circ}05'05.8''$  байрлана.

### **Төлөвлөлт**

Амарбаясгалант хийдийн төлөвлөлт бол гол тэнхлэгийн дагуу таван цуваа байгууламж болох Хaalга, Махранзын сүм, Цогчин дуган, Номын өргөө, Бясалгалын сүмийг төлөвлөдөг Чин улсын сүм хийдийн загварын хамгийн сонгодог хэлбэр юм. Тус хийдийн гол онцлог нь хааны зарлигаар маш цэгцтэй төлөвлөлтийн дагуу байгуулагдсан учир жирийн сүм хийдийн байгууламжаас ихээхэн ялгардаг төдийгүй заримдаа ордны загвартай адил хэмээх эндүүрлийг төрүүлэх нь бий.

Тэнхлэгийн төвд гол барилга байхаар төлөвлөж, түүний эргэн тойронд тэнхлэгийн дагуу болон тэгш хэмийн байрлалтайгаар бусад бүх барилгыг зэрэг дэв, эрэмбэ дарааллаар нь хэрмэн дотор дөрөв шаталсан дэвсэг (террас) дээр байрлуулсан бөгөөд төв рүү чиглэсэн төлөвлөлтийн ерөнхий зарчмыг баримталсан байдаг.

Гэрийн үүд лугаа бүх сүм, дуганы хаалгыг өмнө зүг рүү харуулж төлөвлөсөн нь монголчуудын эртнээс мөрддөг төлөвлөлтийн горимыг тусгажээ.

Хийдийн гол тэнхлэг дээр Тамгын сүм, Махранзын сүм, Цогчин дуган, Зуугийн сүм, Лавран байхаар төлөвлөсөн ба Цогчин дуган нь уг хийдийн «төв» болж байна. Цогчин дуганыг жижиг мэлхий хэрэм бүхий дэвсэг дээр байгуулж, түүний өмнө талд Түүхийн хоёр сүмийг тэгш хэмийн байрлалтай байхаар, ар талд нь Зуугийн сүмийг тэнхлэг дээр, түүний хоёр талд

I, IV Богдын шарилын сүм, Манал, Аюушийн сүм тэгш хэмийн зохион байгуулалттайгаар тус тус төлөвлөсөн байна. Эдгээр найман барилга нь хийдийн гол сүм дуган учир Цогчин дуганы хамт шар хэрмэн дотор хоёр үелсэн дэвсэг дээр төлөвлөжээ. Дээрх барилгуудын дээврийн чимэглэлийг хүрэн паалантай ваараар хийсэн нь тэдгээр барилгын ач холбогдол, зэрэг дэвийг тодорхойлон бусдаас ялгаруулж, хийдийн төв хэсэг гэдгийг тодруулж өгч байгаа юм.


Төв хэсэг болох шар хэрмийн ар талын хэрмийн дотор гол тэнхлэг дээр Лавранг, түүний өмнө талд Түнэлха, Яамны сүмийг төлөвлөсөн байна. Эдгээр сүмийн дээврийн чимэглэл болон дээврийн ваарыг хөх ваараар хийсэн нь мөн л эдгээр барилгын ач холбогдол, зэрэг дэв, эрэмбэ дарааллыг илтгэнэ. Өөрөөр хэлбэл хоёрдугаар зэргийн барилгууд болно. Лаврангийн хоёр талд Нархажид, Майдарын сүмийг тусгай хэрмэн дотор төлөвлөсөн ба паалантай вааран вээвэртэй юм.

Гадна хэрмэн дотор үйлчилгээ, аж ахуйн зориулалттай нэг маягийн арван барилга буюу «Цагаан дуган»-г төлөвлөсөн байна. Тэдгээр барилгын хийц, чимэглэл маш энгийн бөгөөд хөх вааран дээвэртэй байгаа нь түүний зориулалтыг мөн илэрхийлнэ. Хийдийн хэрмийн гадуур хойд, баруун, зүүн талаар нь уулнаас буух борооны усыг зайлцуулах зориулалт бүхий шуудуу хийсэн ба түүний гадуур горооны зам байна.

### **Байгуулалт**

Хятадын эртний уран барилгын байгуулалтын хэмжээнд жан (*zhang*<sup>3</sup>) гэсэн ойлголт байдаг. Баганын хоорондох зайл «жан» гэнэ. Дөрвөн багана, дам нурууны хоорондох зайл нэг өрөө гэх ба хятадын эртний модон бүтээцтэй дан барилгын байгуулалт нь 1, 3, 5, 7, 9 өрөөтэй байх бөгөөд голын тасалгаанаас хоёр тийш тэгш хэмийн байгуулалтаар бусад өрөөнүүдийг зориулалтаас хамааруулан төлөвлөх ба өрөө бүр өөрийн нэртэй. Голын өрөөг «мин (*ming*)», мингийн хоёр талын өрөөг «дэс буюу цы (*ci*)», түүний хоёр талын өрөөг «төгсгөлийн өмнөх буюу шао (*shao*)», түүний хоёр талын өрөөг «төгсгөлийн буюу жин (*jin*)» гэх ба

<sup>3</sup> «*zhang*» - «жан» хятадын уртын нэгж бөгөөд 1 жан = 10 чи = 3.3 м



3 орөөг - мин цы, 5 орөөг - мин цы шао, 9 орөөг - мин, цы, цы, шао, жин гэдэг байна.

Хятадын эртний барилга нь тэгш өнцөгт гонзгой байгуулалттай байдаг бол монголын эртний шүтээний барилга нь тэг дөрвөлжин байгуулалттай байжээ. Голын өрөөг томоор төлөвлөдөг нь гол шүтээнийг байрлуулдаг, гол хаалгыг төлөвлөдөг, бүтээцэд сайнаар нөлөөлдөг, зохиомжийн таатай орон зайл үүсгэдэг зэрэг үүрэгтэйгээс гадна эдийн засгийн хувьд ч хэмнэлттэй байдаг байна.


Монголчууд барилгын том жижгийг тодорхойлон “тэдэн жангийн, эдэн жангийн” барилга хэмээн ярьдаг нь дээрх жан гэсэн ойлголтыг мэддэг байсан ба «жиань» гэдэг хятад үг нь монголчлогдон «жан» гэсэн барилгын хэмжигдэхүүн болсон байна.

Барилгын байгуулалтад галерей<sup>4</sup> (саравч) нэмж төлөвлөснөөр нэгдүгээрт, барилгад шинэ орон зайл үүсгэж сурлэг харагдуулдаг хоёрдугаарт, багана нэмснээрээ бүтээцийг бат бэх болгон барилгыг улам тогтвортой болгодог. Доод зэргийн дан барилгыг галерейгүй хийдэг байна. Галерейг төлөвлөх нь тухайн барилгын ач холбогдол, эзний зэрэг дэвийг тодорхойлдог. Тухайлбал, тэгш өнцөгт байгуулалттай барилгын нүүр талд


<sup>4</sup> «галерея» - францаар galerie, италиар galleria, оросоор галерея, монголоор галерей, гудамлаг

эсвэл нүүр болон ар талд хоёуланд галерейг төлөвлөсөн бол дунд зэргийн барилгад тооцогдох ба байгуулалтын дөрвөн талд галерей төлөвлөвөл дээд зэргийн барилгыг илэрхийлиэ.


Энэхүү галерей гаргах төлөвлөлтийн аргыг XVII зууны үеэс монголын шашин шүтээний барилгад хэрэглэх болсон юм. Үүнээс өмнө буюу Богд Зонховын шашныг дэлгэрэхээс өмнө хааны ордны барилга ба шүтээний барилгын гол өрөөний эргэн тойронд гудам гаргах аргыг өргөн хэрэглэж байжээ. Өөрөөр хэлбэл гудам гаргаж, давхар хана хийхийн оронд нүүрэн талд нь тагт, нүүр, ар талд болон эргэн тойрон галерей хийх болсны нэг жишээ нь Амарбаясгалантын гол дуган Цогчны төлөвлөлтөнд харагддаг. Цогчин дуганы нэг, хоёрдугаар давхрын байгуулалтын эргэн тойронд галерейг төлөвлөсөн нь уг барилгын зориулалт, хэмжээ, эзний зэрэг дэв зэргийг тодорхойлж байгаа болно. Нөгөө талаар гороолоход тохиромжтой юм.




Галерейгүй



Нэг галерейтай




Хоёр галерейтай



Дөрвөн галерейтай

Амарбаясгалантын барилгуудын байгуулалтыг авч үзвэл 3-аас дээш өрөөтэй бөгөөд Цогчин дуган, Түүхийн 2 сүм эргэн тойрон галерейтэй, Манал, Аюуш, Түнэлха, Яам, Лавран, Майдар, Нархажидын сүм, 2-9 дүгээр Цагаан дуган нь нүүрэн талдаа галерейтэй бусад бүх барилга буюу Тамгын сүм, Махранз, Жин хонх, хэнгэрэгийн сүм, Зуугийн сүм, I, IV Богдын шарилын сүм, 1 дүгээр Цагаан дуган нь галерейгүй энгийн дан болон



Цогчин дуганы хоёрдугаар давхрын галерей

давхар барилгууд болно.

Амарбаясгалант нь архитектурын хувьд өөрийн гэсэн өвөрмөц төлөвлөлт, зохион байгуулалттайгаас гадна түүний инженерийн зарим шийдэлт нь сонирхол татдаг. Энэ нь томоохон барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа газар сонголтоос эхлээд түүний алсаас харагдах байдал (силуэт), архитектур, инженерийн шийдэлт, өнгө будаг, чимэглэл бүгдийг цогц шийдэж байсны тод жишээ юм.

Амарбаясгалант хийд нь  $175,5 \times 207,4$  м хэмжээтэй шар, ягаан өнгийн битүү хэрмэн дотор сүм дугануудын зориулалтаас нь хамааруулан дэс дараалалтай төлөвлөн барьсан бөгөөд одоо байгаа барилга байгууламжийн архитектур, төлөвлөлтийн талаар тайлбарлан бичье.

### Ямпай хаалга

Ямпай – гэж монголчууд хэлж заншсан. «*yang rai*» гэдэг нь «халхавч» гэсэн утгатай хятад үг юм байна. Мөн жо би гэж нэрлэдэг. («*zhaobi*»- хаалт, хана гэсэн утгатай хятад үг) Манжийн хааны зарлигаар байгуулагдсан айлтгалтай хийдийн өмнө талд ямпай хаалгыг хамгаалалт хаалт болгон барьдаг байжээ. Энэ нь *нэгдүгээрт*, тухайн хийдийн эзний сүр хүч, зэрэг дэвийг илэрхийлдэг буюу зарлигтай сүмийн хүндэтгэлийн тэмдэг *хоёрдугаарт*, Ямпай, Тамгын сүмийн хооронд зохиомол орон зайл үүсгэн тусгаарлаж өгдөг байна. Амарбаясгалант хийдийн ямпай хаалга нь  $16.0 \times 0.92$  м хэмжээтэй, чимэглэлийн хувьд бусад хийдийн ямпай хаалганаас ялгаатай. Уг ямпай хаалганы нүүрэн талд ваартай дэлгэрч буй дөрвөн цэцэг, түүний дээр дөрвөн тоть шувууг товойлгон пааландаж дүрсэлсэн байдаг. Дэлгэрч буй цэцэг нь дөрвөн улирлыг, ваар нь амар амгаланг илэрхийлж өөрөөр хэлбэл «дөрвөн улиралд амар тайван байхыг» бэлгэдсэн утгатай юм. Мөн дэлгэрч байгаа цэцэг нь одоо үе, цоморлигоо дэлгээгүй цэцэг нь дараа үе буюу «үр



удам хэзээ ч тасрахгүй» гэсэн утгатай. Ямпайн ар талд толгой, сүүлээрээ зөрсөн хоёр лууг мөн товоилгон паалантай ваараар дүрсэлсэн байдаг. Уг хийдийг хааны зарлигаар байгуулсан учраас хаан ээний сүр хүчийг илэрхийлэн хоёр лууг «арга билэг»-ээр дүрсэлсэн байна. Ер нь дорно дахины уран барилгын чимэглэлд арга билгийг их хэрэглэдэг.


«Арга билэг» гэдэг нь үзэгдэл юмсын эерэг хийгээд сөрөг талыг шүтэн барилдуулах замаар учир ёсыг танин барих дорно дахины гүн ухааны цогц ойлголт юм. Арга билгийн ёсны үүдиээс бол юмсыг бүрдүүлэгч хоёр тал нь бие биенээ үгүйсгэхийн хамт бас нөхцөлдүүлж байдаг жамтай. Энэ нь тухайн зүйлийн өөдлөх уруудах хөдөлгөөн хөгжлийн дотоод сурвалж болдог байна. Энэ тухай эх сурвалжид өгүүлэхдээ “Аргын ёсон хөдлөн, билгийн ёсон нам. Арга үүрд хөдөлж үл болно. Билэг үүрд нам байж үл болно. Арга билгийг түшиж нам болмой. Билэг аргыг дагаж хөдөлмой” гэсэн байна. Ингэхлээр арга билгийн ёс бол юмс үзэгдэл, сав, шим өртөнцийн хөгжлийн чиг хандлагыг илэрхийлсэн гүн утгатай ойлголт болно.

Пайлуур («*pai lou*» – *pai* – зарлал, дугаар, хүндэтгэлийн үг, *lou* – байшин гэсэн утгатай хягад үг юм байна) гэж монголчууд хэлж заншсан. Пайлуур нь ямпайн хоёр талд байдаг бөгөөд пайлуурын дундах улаан шунхаар будсан модон самбар дээр “Олон ван, засаг, тайжаас доош иргэд хүртэл үүн дор мориноосоо буу” хэмээн бичсэн байжээ [Позднеев А. 1896, с.26]. Энэхүү пайлуурын зарлигийг монголын ван, тайж, хүрээний хутагт хувилгаад, жирийн ард хэн боловч хатуу мөрдөж мориноосоо бууж Тамгын сүмийн үүд хүртэл явган явж мөргөл хийдэг байсан байна. Одоо энэхүү зарлигийн үг нь байхгүй болж хоосон самбар үлджээ. Хийдээс 200 м зйтай шөргөн хашаа байсан бөгөөд үүнээс дотогш морьтой хүн нэвтэрдэггүй байжээ. Ямпайн зүүн талын пайлуур нурж үгүй болсныг шинээр сэргээн босгосон.

Ямпайгаас өмнө тийш 130 м орчим зайд шөргөн хайс байжээ. Шөргөн хайс бол зөвхөн манжийн хааны зарлигтай бөгөөд айтгалтай сүмд байдаг.



Ямпай хаалганы хоёр талын чимэглэл



Пайлуур

## **Цамын талбай**

Ямпайн ар талд цам гардаг 14 м-ийн голчтой талбай буюу турван цагираг бүхий цамын гортиг байдаг.

Цам – Энэтхэгийн Бурханы шашны «Дөрвөн аймаг үндэсний» доторх «йогын үндэс» хийгээд «дээр (тэнсэл) үгүйн үндэст» номлосон «очирын бүжиг» гэдэг нууц дотоод бясалгалын бүжгээс уламжлалтай «цам», «гарчам», «цам жахар» хэмээн нэрлэгдсэн шарын шашны багт бүжгийн зүйл VIII зууны сүүлийн мөчлөгөөс Түвшдэд, XVIII зууны дундуураас Монголд шашин номын сүм хийдийн газраа ихэд дэлгэрэх болсон [Хүрэлбаатар Л. 1999, х.74].

Орон хүрээний шүтдэг чойжин сахиус янз янз, газар газрын эзэн савдаг ч өөр өөрийн учир тэдгээрийн үүднээс хийх шашны зан үйл ч өвөрмөц, түүнийгээ дагаад бүжиг цамын дэг ч өөр өөр байжээ.

Амарбаясгалант хийдийн “Цамын талбайн гол цэг гортигийг сорын гортиг гэж нэрлээд, энэ гортигт асар барьж дотор нь сор байрлуулж, хийдийн томоохон ширээт лам, да лам мэтийн томчууд суудаг байжээ. Гадна нэгдүгээр цагирагт 21 шанага сахиулсан догшид нар зогсож, хоёр дахь цагирагт цам бүжиглэн дэглэж, Хүрээ дэгийн 108 цам цөмөөрөө гарч жигдэрдэг байжээ. Мөн ямпайн дэвсэг, цамын талбайн хоёрын дундах замын хажуу талаар эзний тамга, бэрээ тамга, тутамга турван зүйлийг барьцгаан улаан хөх хувцасны өнгөөр ялгаран жагсдаг байжээ. Тус хийдэд жилд 1-2 удаа Майдар эргэсний дараа Хүрээ дэгийн цам гардаг байжээ” [Өлзий Ж. 1999, х.74]. Цамын талбайн ар талд Тамгын сүмийн өмнө талд янгиа буюу дэвсэг байх ба түүн дээр цам гарах үеэр хөгжмийн зэмсэгийг байрлуулдаг байжээ.


Амарбаясгалант хийд эртнээс гаргадаг байсан цамаа сэргээн 2002 оноос эхлэн жил бүрийн намрын эхэн сарын хорин есөнд гаргадаг болжээ.

## **Тамгын сүм**

Тамгын сүм нь манжийн хааны сүлдний сүм бөгөөд хааны тамгыг залдаг ёстой. Их хааны тамгат зарлигийг тавихаас гадна их хааны соёрхсон нэр хаягийг тусгайлан бүтээж үүдэн дээр нь байрлуулна. Тамгын сүмийн хаалган дээрх хаягийн самбарт Манж

Чин улсын хаанаас өгсөн нэрийг буюу «Зарлигаар байгуулсан Амарбаясгалант хийд» гэж манж, монгол, хятадаар бичсэн байдаг.

Энэ уламжлалыг VIII Богд хаан үргэлжлүүлэн Монголын шашин төрийн тэргүүн байхдаа зарлиг буулгаж эрдэмт лам, ноёд, түшмэдийг цуглуулан бэлтгүүлсэн «Монгол Улсын хууль зүйлийн бичиг» (65 дэвтэр)-т Манж Чин улсын үед Монгол нутагт шашны



ямар нэгэн хүрээ, хийд, сүм дуган байгуулбал заавал Манжийн хаанаас нэр гүйж авдаг байсан журмыг уламжлан тус улсын аль ч газар сүм байгуулбаас Дотоод яамаар уламжлан Богд эзэн хаантны зарлигаар




нэр шагнуулж байхын сацуу шагнан байрласан нэрийг түвд, монгол үсгээр хичээнгүйлэн бичүүлж сүмийн хаалганы гадна өлгөх, янтай, шөрөг, мориноос буух хөшөө байгуулж шарын шашныг хүндэтгэж байхыг заажээ.

Тамгын сүм дотор эзний сүлд, манжийн хааны зарлиг, шар, хөх туг, улаан бэрээ (бороохой) мод, Өндөр гэгээний хойд дурийн хутагт нарын алт, мөнгөн баримал, түй мандлын хэрэглэлүүд, долоон эрдэнэ, найман тахил зэрэг байжээ. Сүмийг тусгай шийдвэрээр Майдар эргэх үед онгойлгодог байсан байна. Пайз самбар дээр «Хааны зарлиг» бичсэнийг эзний тамга хэмээх учраас Тамгын сүм гэж нэрлэх болжээ.

Бэрээ буюу задь нь нүдэж балбах, эвдэж хэмхлэх, дарах бяцлах зэвсэг бөгөөд үйлийн үрээс үүсэлтэй мунхагийн хөшиг, сэтгэлийн хир буртагийг хэмхчин хаях үйлдлийг голчлон бэлэгддэг.

Байрлалтын байдал нь урд талаас нэгд бэрээ мод, хоёрт зарлигийн бичиг, гуравт туг байрлаж байжээ. Тэгэхдээ цагаан цэнхэр тугийг зүүн талд нь, шар тугийг баруун талд нь байрлуулах бөгөөд гадаа залж гаргавал мөн энэхүү эрэмбэ дарааллаар байрлуулна [Өлзий Ж. 1999, х.77].

“Эхний хашаанд, хашааны төв дунд нь гол хаалганы чанх эсрэг талд «Тамгын сүм» гэгч оршино. Хийдийн энэ хэсгийг



0 0.5 1м 2м 3м 4м 5м

Тамгын сүм

цэвэр хятад маягийн гэж болох бөгөөд учир нь энэ сүмийн шүтээний гол зүйлс нь гэвэл *нэгдүгээрт* «ээний сүлд», *хоёрдугаарт* монголчууд «тамга» гэж нэрлэдэг Богд хаанаас уг сүмд соёрхсон самбар болох бөгөөд энэ нь хаалган дээр хадсан самбартай яг ижил хэлбэртэй, гагцхүү үүнийг тусгай тавиар суурин дээр байрлуулжээ». гэж А.Позднеев 1892 онд үзсэнээ тэмдэглэж үлдээсэн байна [Позднеев А. 1896, с.27].

Одоо Тамгын сүм дотор талд хаалганы хоёр талд зориулалтын модон хөл дээр туг, бэрээ модны дунд 75,3×58,8 см хэмжээтэй, 5 луугаар чимэглэсэн алтан боронзон хүрээтэй хөх самбар дээр «Хааны зарлиг» (*shengzhi*<sup>5</sup>) гэсэн утгатай хятад үг бичээстэй «Ээний тамга» хэмээгчийг байрлуулсан байна. Энэхүү зарлигийн самбар болон модон тавиур, бэрээ, шар туг бүгдийг шинээр хийсэн бололтой. Түүнээс гадна Тамгын сүм дотор чулуун дээр сийлсэн бурхад, чийганы хуучин дог зэргийг хадгалж байлаа.

Тамгын сүм нь Амарбаясгалантын ерөнхий байгуулалтын гол тэнхлэг дээр байрлах хамгийн эхний сүм бөгөөд маш энгийн хийцтэй, галерейгүй, дүүжин таазгүй, хөх хавтан шалтай, хүрэн паалантай вааран дээвэртэй дан барилга бөгөөд нүүр болон арталдаа нэвт гарах хаалгатай юм.

Анх Тамгын сүмийн дээврийн орой дээр ганжиргүй байсан ба 1990 оны эхэнд суварган ганжирыг шинээр бүтээж суурилуулсан байна.

Ийнхүү Амарбаясгалантын олон сүмийг шинэ ганжиртай болгосон бөгөөд тэдгээр ганжир нь хэмжээний хувьд харьцаагүй том, жижиг болсон байна. Энэ нь архитектурын дурсгалыг анхных нь төрх байдлаар хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын зарчмыг зөрчиж байгаа юм. Ганжирыг шинээр хийж байрлуулахдаа мэргэжлийн түвшинд хийгээгүй, шууд дээврийн гол дэлийг эвдэж дээр нь мод, тоосгон суурь шинээр хийж суурилуулсан нь дээврийн хийцэд нөлөөлж борооны ус дотогш орох нөхцлийг бүрдүүлж модон хийцийг ялзрахад хүргэсэн байна.



Тамгын сүмд байгаа шар туг, Ээний тамга, бэрээ

<sup>5</sup> «*shengzhi*» – монголоор «Хааны зарлиг» гэсэн утгатай. Хаант ёст үед хааны зарлигаар шийтгэсэн аливаа албан хэрэг, бичигт энэ үгийт өргөмжлөн авч хэрэглэсэн байдал. *Sheng* хэмээх эхний ханз нь Богд, Хаан, Эзэн гэсэн утга буй ч «*Shegzhi*» гэхээрээ «Хааны зарлиг» гэсэн хэвшин тогтсон утгаар хэрэглэгддэг байна.